

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны гуравдугаар сарын 25-ны 10 цаг 03 минутад эхэлж, 11 цаг 51 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Эрдэнэбилэгийн Одбаярыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Сангийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн</p>

	<p>сонсгол сонсож хэлэлцэх</p>	<p>4.4 дэх заалтыг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзэх 2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах талаар өгч буй зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг Сангийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Х.Ганцогтод даалгах 3. Энэхүү тогтоол, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
<p>3</p>	<p>Дархан уул, Увс аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 02 дугаар сарын 29, 03 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Дархан-Уул аймаг, Увс аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none"> 1. 2016 оны 02 дугаар сарын 29, 03 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 37 иргэн /Дархан-

		<p>Уул аймагт 33, Увс аймагт 4/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 1 иргэн /Дархан-Уул аймагт 1/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4, 5 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 11 /Дархан-Уул аймагт 9, Увс аймагт 2/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 1 иргэн /Дархан-Уул аймагт 1/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 4-6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 12 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл /Ц.Сүхбаатар/-т, Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөл /Г.Болор-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

4	Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Төрийн нарийн бичгийн дарга 2) Төрийн захиргааны удирдлагын газрын захирал 3) Бодлого, төлөвлөлт зохицуулалтын газрын захирал 4) Хөрш орнуудын газрын захирал 5) Европ Америкийн газрын захирал 6) Ази, Ойрхи Дорнод, Африкийн газрын захирал 7) Эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал 8) Гадаад сурталчилгаа, мэдээллийн газрын захирал 9) Олон талт хамтын ажиллагааны газрын захирал 10) Консулын газрын захирал 11) Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 134 дүгээр тогтоолыг хүчингүй болгох тухай Монгол Улсын</p>
---	--	--

		Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, нэг албан хаагчид тэргүүн түшмэлийн, 12 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

6	Зарим албан хаагчид "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдэг олгох тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 11 төрийн албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах</p> <p>2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнагдсан хүн тус бүрт уг шагналыг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнуулахаар нэр дэвшүүлсэн тухайн байгууллагаас олгох.</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

